



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2022 оны 09 сарын 05 өдөр

Дугаар 49

Мандалговь

Үндсэн хөрөнгөд үнэлгээ тогтоож,  
худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арванхоёрдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Дэрэн сумын Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 29,736,434 /хорин есөн сая долоон зуун гучин зургаан мянга дөрвөн зуун гучин дөрвөн/ төгрөгийн балансын үнэтэй, 3,717,054 /гурван сая долоон зуун арван долоон мянга тавин дөрвөн/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй 86-87 ДУА улсын дугаартай УАЗ 3962 маркийн фургон автомашины худалдах доод үнийг 3,700,000 /гурван сая долоон зуун мянган/ төгрөгөөр тогтоон, нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Орон нутгийн өмчийн газар (Б.Адъяасүрэн), Дэрэн сумын Эрүүл мэндийн төвийн дарга (Ю.Янжиндулам) нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.


2.1 Эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу худалдаж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг орон нутгийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд бүрэн төвлөрүүлэх.

2.2 Хөрөнгийг худалдсаны дараа хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх.

2.3 Энэ тогтоолын биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.ОД-ЭРДЭНЭ





Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн  
79 дүгээр тогтоолын хавсралт

Дэрэн сумын Эрүүл мэндийн төвийн дуудлагаар худалдах тээврийн хэрэгслийн мэдээлэл

№	Тээврийн хэрэгслийн төрөл	Марк	Улсын бүртгэлийн		Үйлдвэрлэсэн он	Ашиглалтад орсон огноо	Тээврийн хэрэгслийн			Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
			Серийн дугаар	Дугаар			Арлын дугаар	Моторын эзлэхүүн /см3/					
1	Суудал	УАЗ 3962	ДУА	86-87	2017	2017-03-11	220695 Н04038 06	2693	13128 3	29,736,434	26,019,380	3,717,054	3,717,054 /гурван сая долоон зуун арван долоон мянга тавин дөрвөн/ төгрөг
Хөрөнгийн дүн													29,736,434 /хорин есөн сая долоон зуун гучин зургаан мянга дөрвөн зуун гучин дөрвөн/ төгрөг